

1990 ОНЫ МОНГОЛЫН АРДЧИЛАЛ: ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ НӨЛӨӨЛӨЛ

Ч. Тамир *

Монгол 1990 оны ардчилсан хувьсгал үүсэхэд хүчин зүйлийг судлаачид гадаад ба дотоод хүчин зүйл гэж ангилдаг бөгөөд энэхүү өгүүлэлд гадаад хүчин зүйлийг авч үзэхийг зорьсон болно. Судлаачдын бүтээлээс харахад тэд гадаад хүчин зүйлийг чухал гэдгийг санал нэгтгэйгээр зөвшөөрч байгаа бөгөөд зохиогч гэсэн үүнтэй санал зөрөлдөхгүй байгаа, гэхдээ гадаад хүчин зүйл нь хэр зэрэг ач холбогдолтой байсан гэдэг дээр нэгдүгээрт шийдвэрлэгч ач холбогдолтой байсан, хоёрдугаарт гадаад хүчин зүйл нь дотоод хүчин зүйлийг нээх хаалтыг нь авч хаяхад нөлөөлсөн бөгөөд улмаар монголын ардчилал нь өөрийн дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр үндэсний өнгө аястай явагдсан гэсэн байр суурь байна. Тухайлбал хоёрдугаар байр суурийг нэлээд үндэслэлтэй дэвшүүлсэн судлаач бол Д.Болд-эрдэнэ бөгөөд тэрээр гадаад, дотоод хүчин зүйл хэрхэн харилцан үйлчлэлцсэн тухай маш нухацтай авч үзээд дараах үндэслэлийг гаргажээ. “Монгол орны хувьд энэ нь “социалист” гэгдэж байсан улс орнуудад явагдсан ардчилал, шинэтгэлийн үйл явц болон манай нийгмийн гүнд хуримтлагдсан зөрчил, бэрхшээл, хямралт нөхцөл байдалтай холбоотойгоор бүрэлдэн бий болсон билээ. М.С.Горбачевийн өөрчлөн байгуулалтыг Монголд ардчилсан хувьсгал гарах шууд шалтгаан болж өгсөн гэж үздэг хэсэг нэлээдгүй байдаг. Өөрчлөн байгуулалт нь манайд явагдсан ардчиллын үйл явцад хүчирхэг нөлөө үзүүлсэн гэдэгтэй хэн ч маргахгүй байх. Гэхдээ монгол дахь ардчилсан хувьсгалын шууд учир шалтгааны асуудлыг зөвхөн ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр тайлбарлах нь өрөөсгөл юм. Горбачевийн өөрчлөн байгуулалт нь монголын нийгмийн гүнд олон арван жилийн турш бугшин хуримтлагдсан гүнзгий хямрал гажуудлыг сэдэрэн ил тодорхой болгоход нөлөөлсөн гадаад шалтгаан, гол хүчин зүйл болсноос биш тус орон дахь ардчилсан үйл явцын дан ганц шууд шалтгаан хараахан байж чадаагүй юм. Тиймээс ч монголд өрнөсөн ардчилсан хувьсгалын үйл явцыг гагцхүү тус орны нийгмийн дотоод бодит учир шалтгаан, хүчин зүйлсийн нөлөөллийн хүрээнд авч үзэн тайлбарлах нь зохистой юм”¹ гэжээ. Мөн С.Зориг энэ тухай “Гадны нөлөө гэвэл 1985 оноос ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалт. Түүнийг дагаад Дорнод Европийн орнуудад эрчимтэй өрнөсөн өөрчлөлтийн үйл явц түлхэц болсон. Энэ бүхэн нь дотоодод бий болсон ардчилсан хөдөлгөөнтэй нөхцөлдсөн” гэжээ.²

* МУИС-ийн НШУС-ийн багш докторант

1. Д.Болд-Эрдэнэ, 2000 х36-37)

2. (Янжинлхам, 2012х23)

Тиймээс энэхүү өгүүлэлд гадаад хүчин зүйлийг **нэгд**, Горбачевийн өөрчлөн байгуулалт, гадаад бодлого, **хоёрт**, Зүүн Европийн улс орнуудад дэглэм солигдсон, **гуравт**, Эдийн засгийн харилцан туслах зөвлөл³ ба ЗХУ-ын тусламж дэмжлэг зогссон, **дөрөвт**, БНХАУ-д Тянь Мян Аний талбайд жагсагч оюутнуудыг хүч хэрэглэн дарсан зэрэг нь Монголын гадаад бодлогод асар хүчтэй нөлөөг үзүүлсэн бөгөөд эдгээрийг тус бүрд шинжилгээ хийж үзэв.

ЗХУ дахь Горбачевийн өөрчлөн байгуулалт, гадаад бодлого

ЗХУ-д өөрчлөн байгуулалтыг 1985 оны 3 сарын 11-нд М.Горбачев ЗХУ-ын Коммунист намын ЕНБД болсноор эхэлжээ. Түүний өөрийн илтгэлд тэмдэглэснээр ЕНБД болохоос өмнө “улс орон маань хямралын босгон дээр байна” гэсэн дүгнэлтэнд хүрсэн байсан бөгөөд улмаар 4 сард болсон НТХ-ны бүгд хурал дээр албан ёсоор томьёолж оруулсан байна⁴. Үнэхээр энэ үед ЗХУ-ын дотоодын эдийн засгийн нөхцөл байдал доройтож, зэвсэглэлд төсвийн хэт их хувийг зарцуулдаг, эдийн засгийн зогсонги байдал нь улс орныг бүхэлд нь туйлдуулжээ. Шинэ албан тушаалд томилогдсоны дараах нөхцөл байдлыг дүгнэж хэлэхдээ “Хуучин байдлаараа явах ямар ч аргагүй болсон байсан” хэмээн хэлсэн юм⁵. Тэрээр өөрийн багийг бүрдүүлж ЗХУ-ын улс төр, эдийн засгийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх үйл явцыг эхлүүлэв. Энэ нь дараах хэдэн бүрэлдхүүн хэсэгтэй байв.

Эхний шатанд 1985 оноос анх “ил тод байдал” хэвлэл мэдээллийн хэрэгслийг нээлттэй болгохоос эхлэв⁶. Үүгээрээ тэрээр “главлиг”-ийг устгасан бөгөөд бүхий л шатны байгууллагууд бүхий л

³ (Comecon)

⁴ (Горбачев, 1988x21-22)

⁵ (CNN, 2004)

⁶ (Matthews, 1989)

төрлийн хуримтлагдаад байгаа асуудлаа ил тод дэлгэж хэлэлцүүлэг хийх ёстой гэжээ. 1986 оны 2 сард ЗХУКН-ын XXVII их хурлаас шинэ сэтгэлгээ зайлшгүйг онцлон тэмдэглэж улмаар өөрчлөн байгуулалтын тодорхой санааг дэвшүүлжээ⁷. Үүнтэй холбоотой өмнө нь ЗХУ-д нууц гэж үздэг байсан олон сэдэв материалуудыг зөвлөлтийн хэвлэлүүд илэн далангүй хэвлэж эхлэв. Улмаар 1987 оны долоон сарын 7-ны “Ил тод байдлын хууль”-ийн төслийг хэлэлцүүлж⁸ эхэлсэн ба мөн XIX намын хурлаас “Ил тод байдал”-ын тухай тогтоол гаргасан юм⁹. Ингээд 1985-1988 он хүртэл гурван жил “ил тод байдал”-ыг дэвшүүлсэн бөгөөд түүгээр дамжуулан нам, төр, олон нийтийн байгууллагууд илэн далангүй шүүмжлэлийг өрнүүлсэн бөгөөд “шүүмжлэл”, “өөрийн шүүмжлэл” чухал байр суурийг эзэлж байжээ¹⁰. Дараагийн шатанд 1988 оны 4 сарын 28-нд Москвад болсон ЗХУКН-ын XIX бага хуралд М.С.Горбачев “ЗХУКН ХХҮИ их хурлын шийдвэрийн биелэлтийн явц, өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлэх тухай” илтгэлд нэгдүгээр хэсэг нь эдийн засгийн шинэчлэл, хоёрдугаар хэсэг нь улс төрийн системийн гажуудалд орсныг шинэчлэх, гуравдугаар хэсэг нь ЗХУКН-ын дотоод ардчиллыг хөгжүүлэх асуудлыг хөнджээ. Улмаар тус хурлаас “ил тод байдал”-ийг хөгжүүлэх дэмжихэд “өөрчлөн байгуулалт” маш чухал зэвсэг гэж зааснаар “өөрчлөн байгуулалт” гэсэн үг шинээр гарч иржээ¹¹. Энэ хоёр ойлголтын өөр хоорондын харьцааг тогтоолд заахдаа “ил тод байдал” нь одоогийн нийгмийн нөхцөл байдал, бодит үнэнийг мэдэхэд бидэнд туслана”, “ил тод байдал нь бүхий л олон нийтийн хүчний “өөрчлөн

⁷ (Яскина, Трансформация монгольского общества, 2007 х314)

⁸ (Закон о гласности, 1987 /12/)

⁹ (О гласности, 1988)

¹⁰ (Matthews, 1989х156)

¹¹ (О гласности, 1988)

байгуулалт”-ын зарчим, санааг хэрэгжүүлэхэд чиглэнэ” гэсэн юм. Улмаар нээлттэй байдлын ачаар эдийн засгийн зогсонги байдлыг харуулсан бэрхшээл тодрон гарч ирэв. Тиймээс эдийн засгийг хурдасгахын тулд хийх зүйлс 1987 оны 6 сард “Зөвлөлтэй хамтарсан үйлдвэрийн тухай хууль”, 7 сард “Улсын Үйлдвэрийн хууль” батлагдав. 1988 оны 1 сард “Төв засгийн газар улсын үйлдвэрийн газрын эдийн засгийн өрийг хариуцахгүй” гэсэн алдартай мэдэгдэлээ хийжээ. Мөн оны 5 сард “Хоршооллын хууль”¹² батлаж гарав. Эдийн засгийн асуудлуудаа шийдэхийн тулд цэргийн зардлыг бууруулах өнөөдрийг хүртэл баримталж ирсэн гадаад бодлогоо эргэн харах шаардлагатай болжээ.

Тийм учраас дараагийн цогц шинэчлэлийн бодлого нь гадаад харилцаа, аюулгүй байдлын номлолоо үндсээр нь өөрчлөх шаардлагатай болов. Горбачевийг дээд удирдлагад гарч ирэхэд дээд удирдлагын системд цэргийнхэн маш их хүчтэй байлаа. Тийм ч учраас тэрээр 1986-1987 онуудад цэргийн зардлыг багасгаж чадаагүй юм. Харин 1988 оноос тогтвортойгоор цэргийн зардлыг багасгав¹³. Үүний бэлтгэл болгож зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоож Афганистанаас цэргээ гаргажээ¹⁴. Мөн зэрэгцүүлэн улс төрийн системийн шинэчлэл, намын өөрийн ил тод байдал шинэчлэлийн асуудлыг хөндлөө. 1987 оны 2 сарын ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчдийн “Орон нутгийн Ардын Депутатын Зөвлөлийн сонгуульд олон нэр дэвшигч дэвшүүлэх туршилтийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай”¹⁵ тогтоол гарсан юм. Энэ туршилтын сонгууль өмнө нь нам буюу комсомолоос санал болгосон дэвшигчийг 99 хувиар сонгохыг тулгадаг байдаг

¹² (Закон СССР о кооперации в СССР, 1988)

¹³ (Matthews, 1989)

¹⁴ (CNN, 2004)

¹⁵ (Ведомости Верховного Совета РСФСР, 1987)

өмнөх туршлагыг халж тухайн суудлаас олон тооны нэр дэвшигчийг дэвшүүлэх боломжийг олгож хүмүүст сонголт бий болгосноороо барууныхны анхаарлыг ихээхэн татсан төдийгүй түүнд оролцсон орон нутгийн иргэдэд ч гэсэн ихээхэн таалагджээ. Раймонд нарын судалгаагаар “Тухайлбал 1987 оноос өмнө зөвхөн нэг нэр дэвшигчийн төлөө орон нутгийн нам болон комсомолын байгууллагын зааварчилгаагаар өрсөлдөөнгүйгээр дээрээс санал болгосон хүнийг сонгодог байв. 1987 оны 6 сард Москвагийн санаачлагаар олон нэр дэвшигчтэй орон нутгийн туршилтын сонгуулийг нийт дүүргүүдийн 5 хувиас илүү дээр нь хийжээ. Энэ нь тухайн албан тушаалын тооноос илүү нэр дэвшигчийн жагсаалтыг танилцуулж сонгогчид нь шаардлагатай тооны албан тушаалын тоотой тэнцүү тоогоор хүмүүсийн нэрийг хэрээслэх байдлаар сонголтоо тэмдэглэнэ. Энэ реформ нь орон нутгийн удирдлагуудад таалагдаагүй боловч олон нийтэд эсрэгээрээ байв¹⁶. Үүний дараа 1988 онд “Ардын депутатуудын конгресс”-ийн депутатыг сонгох сонгуулийн хуулийг баталсан байна. Энэ хуулиар 1917 оноос хойш анх удаа хэд хэдэн нэр дэвшигч дэвшүүлэхийг зөвшөөрчээ. Сонгууль 1989 оны 3-4 сард болж 5974 нэр дэвшигч 2250 суудал дээр өрсөлдөж¹⁷ хүмүүс сонгогдсон байна. Мөн онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлтийн оруулжээ. Сүм хийдтэй харьцах харьцаагаа 1985 оноос эхлэн зөөлрүүлэв. Боловсон хүчний шинэчлэлийг огцом хийлээ. Тухайлбал 1981 оны ЗСБНКН-ын XXVI их хурлаас ТХ-ны гишүүнээр сонгогдсон гишүүдийн 25 хувь нь дахин сонгогдоогүй бол 1986 оны XXVII их хурлаар 41 хувь, орлогчийн 68 хувь нь солигдсон юм. 1989 оны 4 сарын 25-ны ТХ бүгд хурлаар 76 гишүүнийг өөрчилж 24 орлогчийг гишүүн болгож дэвшүүлж нийтдээ

¹⁶ (Raymond, 1991 x365)

¹⁷ (Raymond, 1991 x347)

251 гишүүн, 109 орлогч гишүүнтэй болжээ. Ингэхдээ ТХ гишүүдийн дотор намын аппаратын ажилтнуудын эзлэх хувийг 44.5 хувиас 33.9 хувь болгож багасган, цэргийнхнийг 8.5-аас 4.4 хувь болгож бууруулсан бөгөөд эсрэгээрээ ажилчин ба тариачин 8.5 хувь байсныг 14.3 хувь болгож ихэсгэжээ¹⁸. Энэ бол урд өмнө хийгдэж байгаагүй томоохон халаа сэлгээ болов. 1985 оноос хойш ЗХУ-д өөрчлөн байгуулалттай холбоотой явагдсан гол реформыг Монголтой харьцуулбал дараах дүр зураг харагдаж байна¹⁹.

¹⁸ (Raymond, 1991 x297)

¹⁹ (Watson 1997 x)

| М. С. Горбачёвын манлайлал (Matthews, 1989) | Ж.Батмөнхийн манлайлал |
|--|---|
| 1985-3-11 М.Горбачёв Ерөнхий нарийн бичгийн дарга болов | 1984 МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болов. |
| 1986 оны 4 сард “Гласность” эхлэв. 1986 оны 12 сар Андрей Сахаровыг суллажээ 1986 “Хувь хүмүүсийн хөдөлмөрийн үйл ажиллагааны тухай хууль” батлагдав. | 1986 оны 6 сард “Үйлдвэрлэлийн үр ашиг, чанарыг дээшлүүлэх зорилтын тухай” СнЗ-ын даргын илтгэлийг хэлэлцэв. |
| 1987 оны 1-р сард ТХ-ны хурал болж Горбачёв “намын дотоод ардчиллыг бэхжүүлэх” чиглэл гаргажээ 6 сард Зөвлөлтэй хамтарсан үйлдвэрийн тухай хууль батлагдав. 7 сард Улсын Үйлдвэрийн хууль батлагдав. 7-8 сард М.Горбачёвын “Өөрчлөн байгуулалт” ном нь хэвлэгдэн гарчээ. | Ж.Батмөнх 1987 онд МҮЭ-ийн XIII их хурал дээр “Өөрчлөн байгуулалт бол манай чиг баримжаа мөн” гэж хэлжээ. |
| 1988 оны 1 сард Төв засгийн газар улсын үйлдвэрийн газрын эдийн засгийн өрийг хариуцахгүй гэдгээ мэдэгджээ. 5 сард Хоршооллын хууль батлагдав. 10 сард Олон нэр дэвшигч дэвшүүлж АДХ өрсөлдүүлэх Сонгуулийн хуулийг баталжээ 12 сард Үндсэн хуульд орон нутгийн эрх мэдлийг өргөтгөсөн нэмэлт өөрчлөлт оруулав 12 сард НҮБ-ийн хурал дээр Афганы дайныг дуусгаж цэргээ хорогдуулах шийдвэр гаргаснаа зарлав. | 1988 оны 6-р сард “БНМАУ өөрийн өвөрмөц нөхцөл бололцоо, түүхэн онцлог, ах дүү орнуудын өөрчлөн байгуулалтын туршлагын аль алиныг нь харгалзан үзэх үүднээс хандаж байна” гэж мэдэгджээ 1988 оны 12 сарын 21-нд “Намын зохион байгуулалт үзэл сурталын ажлыг сайжруулах шинэ зорилтын тухай” (Батмөнх, Үнэн, 1988) 1. Намын дотоод ардчиллыг 2. Олон нэр дэвшигчтэй АДХ-ын сонгууль 3. Түүхийн толбыг цагаатгах 1988 оны 11 сард “Улсын үйлдвэрийн тухай хууль” батлагдав. |
| 1989 оны 3-р сард АДХ-ын сонгууль болов. 7 сард зөвлөлтийн эдийн засагт шинэчлэл хийх арга замыг боловсруулах “Эдийн засгийн реформын комисс”-ыг батлав. 10 сараас “зөвлөлтийн эсрэг” хөдөлгөөн эхэллээ. 12 сард Малтагийн уулзалтаар хүйтэн дайн дууссаныг албан ёсоор АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш зарлав. | |
| 1990 оны 3-р сард ЗХУКН-ын удирдан дангаар удирдан чиглүүлэх заалтыг хүчингүй болгов | 1990 он нэг сард “Хоршооны тухай хууль” батлагдав, 1990 оны 3 сард “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” тус тус батлагджээ (Mearns 1991x30) 1990 оны 3-р сарын 11-нд МАХН-ын УТТ бүрэн бүрэлдхүүнээрээ огцров. 3 сарын 21-нд МАХН-ын дангаар удирдан чиглүүлэх үүргийн тухай заалтыг хүчингүй болгов. |

Хүснэгтээс харахад Монголын өөрчлөн байгуулалт нь Горбачёвын өөрчлөн байгуулалтын бодлогыг шууд хуулбарласан бөгөөд цаг хугацааны хувьд 2 жилээс доошгүй хугацаагаар хоцорч явж ирсэн зөвлөлтийн дагуул улс байсантай холбоотой. Тиймээс социалист системийн бусад орнуудтай харьцуулвал зөвлөлтийн аливаа бодлого нь Монголд илүү их нөлөөг үзүүлжээ.

Зүүн Европийн социалист орнуудад дэглэм солигдсон нь

Монголын ардчиллыг зарим утгаар нь У.Баркманн “Тус орны улс төрийн дотоодод явагдсан шинэчлэл нь Дорнод Европийн социалист улсуудад болсон үйл явцын шууд бүтээгдхүүн юм”²⁰ гэжээ. Газар зүйн хувьд дотоод азид оршдог энэ улсад яагаад тийм хүчтэй нөлөө үзүүлэв гэдэг хариултгүй асуулт гарч ирнэ. Ардчилал хөгжихөд нөлөөлдөг бас нэг хүчин зүйл нь тухайн орны газар зүйн байрлал нь барууны орнуудаас хэр зэрэг ойр эс бөгөөс алслагдсан байгаа байдал юм. Энэ талаар монголыг хуучин социалист байсан орнуудтай харьцуулан судалсан өгүүллийг С.Фиш бичсэн байдаг. С.Фишийн өгүүлэлд Монгол нь ардчилсан орнуудаас ихээхэн алслагдсан тухай сонирхолтой дүгнэлт гарч ирнэ. Тэдний дүгнэлтээр барууны нөлөөнөөс холдох тусмаа ардчилалд учрах бэрхшээл их болж ирнэ, гэтэл монголын жишээ үүнээс өвөрмөц байгааг тэмдэглэжээ²¹. Чухамдаа монгол нь Азийн хамгийн анхны коммунист дэглэмийг хүлээн зөвшөөрсөн орон, мөн Азийн хамгийн анхын коммунизмаас ардчилал руу шилжилт хийсэн орон. Азийн БНХАУ, Вьетнам, Умард Солонгос зэрэг олон орнуудад тэгвэл Дорнод Европид болсон үйл явц

²⁰ (Баркманн 2008 х27)

²¹ Fish, S. (2000). The Inner Asian Anomaly: Mongolia's Democratization in Comparative Perspective. *Mogolian Political and Economic Development During the Past Ten Years and Future Prospect*, (pp. 87-110). Taipei.

нөлөөлөөгүй тэд хуучин дэглэмээ хадгалж өнөөг хүртэл явж ирэв? Тэгэхлээр энэ гадаад хүчин зүйл дангаараа нөлөөлөөгүй мөн дотоод хүчин зүйлтэй харилцан үйлчлэлцсэн үү? Тэгвэл ямар сувгаар хэрхэн, яаж нөлөөлөв гэдэг асуултанд хариулт өгөх шаардлагатай. Зохиогчийн бодлоор Зүүн Европийн орнуудад болж өнгөрсөн эдгээр үйл явдлууд нь монголын үйл явдалд дараах хэдэн сувгаар нөлөө үзүүлсэн байна.

Хуучин социалист блокод байсан Зүүн Европийн улс орнуудын Польш, Чехославак, Унгар, Зүүн Герман зэрэг орнуудыг голлон авч үзье. Ерөнхий нөхцөл байдлын хувьд Крамерийн судалгаагаар 1988 оны хавраас эхэлж Горбачевийн Зүүн Европт явуулж байсан бодлого 5 үндсэн хүчин зүйлээс бүрдэнэ. Үүнд **нэгд**, 1988 оноос л Горбачевийн эрх мэдэл нь бүрэн бэхэжсэн ба өөрийн орондоо Зүүн Европт өөрийн бодлогыг явуулах боломж нь бүрджээ, **хоёрт**, Горбачев 1988 оноос л эдийн засгийн шинэчлэлийг ЗХУ ба Зүүн Европид улс төрийн реформ хийхгүйгээр хийж чадахгүй гэдэгт итгэлтэй болсон” ба “Түүний түүний дотооддоо явуулсан бодлого эрс хүчтэй байсан бол харин бусад социалист орнуудад хийгдэх суурь өөрчлөлттэй эвлэрч байсан, **гуравт**, 1988 оноос Горбачев эрх мэдлийг Коммунист намаас төрийн хууль тогтоох байгууллагад шилжүүлсэн ба ийм институтийн шилжилт нь намын удирдлагын үүргийг бүрэн чөлөөлөөгүй ч бусад социалист орнуудын дотоод асуудалд хөндлөнгөөс оролцохыг багасгаж өгсөн, **дөрөвт**, 1988-1989 онуудад тасралтгүй өсч байсан эсэргүүцэл, тэмцэл өргөн хүрээтэй шинэчлэл хийх шаардлагатай гэдгийг харуулсан, **тавд**, 1987-1988 онуудад барууныхантай харилцаагаа сайжруулсан нь ЗХУ цаашдаа Зүүн Европт хяналт тавих

үүргээс нь чөлөөлсөн, баруунтай хийх худалдааг ихэсгэх найдварыг төрүүлж байжээ²².

Барууны судлаачид “өөрчлөлтийн эхний шинж тэмдэг Горбачевийг Югославд хийсэн айлчлалын үеэр хамтарсан мэдэгдэл “дотоод хэрэгт нь оролцохгүйгээр тэгш эрхийн зарчмыг баримтлан”, мөн социалист орнууд өөрсдийн замыг өөрсдөө сонгох эрхтэй” гэсэн “нөхцөл заагаагүй” байр суурийг онцлон үздэг. 1988 оны таван сарын 18-нд “Летературная газета” сонинд Вячеслав Дашичевийн бичсэн “Дорнод-Өрнөд” хэмээх өгүүлэл үүнийг нэг жишээ юм. Чухам үүнтэй ижил Зөвлөлтийн гадаад бодлогыг шүүмжилсэн олон өгүүллүүд хэвлэлээр чөлөөтэй гарч эхэлжээ. Дараагийн шинж тэмдэг нь 1988 оны 12 сард НҮБ-ийн Ерөнхий Ассемлей болохын өмнө ЗХУ Зүүн Европт зэвсэглэлээ бууруулах шийдвэр гаргаснаа зарласан явдал юм. Энэ нь баруун ба зүүнийхний харилцааг сайжруулахад зүй ёсоор эерэг нөлөө үзүүлсэн билээ. Ийм шийдвэр гаргахыг ЗХУ-ын УТТ-ны зарим гишүүд эсэргүүцэж байв.

Ингэж Горбачевийн явуулсан бодлогын үр дүнд социалист систем улам бүр чөлөөтэй болсон юм. Горбачевийн явуулсан бодлогыг Варшавын гэрээний орнууд хүлээж авч байгаа байдлаараа хоёр хуваагдаж байв. Польш, Унгарын удирдлагууд дэмжиж байсан бол Чехословак, Зүүн Герман, Болгар, Румыны удирдлагууд дэмжихгүй байв²³. Эхний суурь өөрчлөлт Польш, Унгарт гарлаа. Польшийн хувьд бүр 1976 оноос үнийн өсөлтийн эсрэг тэмцлийг ажилчдын “Ажилчдыг хамгаалах хороо” зохион байгуулж эхэлсэн байна. Удалгүй 1977 оноос “самиздат” буюу хориотой материалууд

²² (Kramer, Fall 2003)

²³ (Kramer, Fall 2003 x186)

хэвлэгдэж эхэлжээ²⁴. Сонирхолтой нь Монголын “самиздат” нь Баабарын “Бүү март мартвал сөнөнө” бөгөөд үүнийг судлаачид 1988 оны тарсан гэж үздэг²⁵. Улмаар 1978 онд Гданскад нууц холбоо үүсч 1979 онд Ромын Пап анх удаа польш хүн болсон ихээхэн нөлөөлжээ. 1980 оны 8 сард “Эв нэгдэл” нэртэй үйлдвэрчний эвлэл бий болж, удалгүй 1981 оны 9 сард “Эв нэгдэл”-ийн үндэсний конгресс болсон байна. Дараа жил нь “Эв нэгдэл”-ийг хориглосон бөгөөд 1983 онд пап Жон Паул хоёрдах айлчлалаа Польшид хийжээ. 1985 оны 4 сард Эрх чөлөө ба энхтайван хөдөлгөөн өрнөж 1987 он гэхэд эсэргүүцэл улам хурцадсан байна²⁶. Чехословакийн хувьд гэвэл 1977 онд “Чартер 77” форм үүссэн бөгөөд 1978 онд Вацлав Хавел “Эрх мэдэл ба эрх мэдэлгүй” хэмээх номоо бичсэн. 1981 оноос Словакид ногоон хөдөлгөөн үүсч, 1985 оны 7 сард Вэлэхрадад жагсаал болсон байна. 1987 оны 4 сард Горбачев тус оронд айлчилсан ба “Чартер 77”-гийн байгаль орчны форум нь зохиогдов. Унгарын хувьд 1977 оны 1 сард “Ардчилсан сөрөг хүчин” идэвхжиж 1979 онд Жозеп Мерза цэргийн албанаас үзэл бодлоосоо татгалзсан нь шуугиан тарьжээ²⁷. 1982 оны зун “Яриа хэлэлцээрийн төлөө энхтайвны групп” үүсч 12 сард тэрс үзэлтнүүдэд хатуу арга хэмжээ авсан байна. 1985 онд олон нэр дэвшигчтэй сонгуулийг хийсэн бөгөөд сөрөг хүчин эрх баригчид лидерүүдтэй уулзсан байна. 1987 оны 1 сараас ардчилсан сөрөг хүчин “Шинэ нийгмийн гэрээ”-г дэвшүүлж 9 сард үндэсний болон сөрөг хүчний төлөөлөгчдийн уулзалт “Лакителеки”-д болсон байна²⁸. 1988-1989 онд Унгар ба Польшийн эрх баригчид маш томоохон хэмжээний

²⁴ (Kenney, 2002 x20)

²⁵ (Atwood C. P., 2004)

²⁶ (Kenney, 2002 x20)

²⁷ (Kenney, 2002 x20)

²⁸ (Kenney, 2002 x20)

шинэчлэлийн бодлогыг явууллаа. Социалист дэглэм эдгээр улсуудад нурж уналаа. Горбачев 1989 оны 7 сард Европийн Парламентад үг хэлэхийн өмнө тэрээр “Правда” сонинд 7 сарын 7-ны өдөр хэлсэн үгэндээ “эдгээр орнууд өөрсдийн бодлого, хувь заяагаа өөрсдөө сонгох бүрэн эрхтэй, аль нэг орон хөндлөнгөөс оролцох ёсгүй” хэмээн мэдэгдсэнээр эдгээр орон мөн цаашид бусад орнуудад хийгдэх реформ түүнийг дагалдан гарах үр дүнд ЗХУ хөндлөнгөөс оролцохгүй хэмээн албан ёсоор мэдэгдсэн юм²⁹. Бусад орнуудын удирдлагууд нь “хатуу коммунист” дотоод бодлогоо либералчлахыг хүсэхгүй байсан ч Горбачеваас ирж байсан шахалтын үр дүнд 1989 оны дунд гэхэд өөрчлөлт хийгдэж тодорхой үр дүн гарна гэдэг нь тодорхой болоод байв³⁰. 1988 он 10 сард Горбачевийн Зүүн Европийг хариуцсан туслах, реформын зөвлөхүүдийн нэг Георгий Шахнаразевийн бэлтгэсэн “Нууц меморандумд “ах дүү орнуудад үүсээд байгаа нөхцөл байдал нь бүгдээрээ ижил үндэстэй байна, цаашид ч улам тэлэх хандлагатай байна, тодорхой баримт бол эдгээр орнууд нь социализмын улс төр эдийн засгийн загварыг манай улсаас авч хэрэглэж байгаа бөгөөд үүнийг шинэчлэн сайжруулах шаардлага зүй ёсоор үүсээд байна” хэмээн бичсэн бөгөөд үүнийг ЗХУКН-ын УТГ танилцуулж байжээ”³¹. Горбачевийн өөр нэг нөлөө бүхий зөвлөх Виталия Зуркин “Зүүн Европийн орнуудад үүсээд байгаа авторитар ба тоталитар дэглэм нь мөнхөд оршин тогтнож чадахгүй гэдэг нь тодорхой байлаа. Хэрвээ бид дэглэмийг цаашид хэвээр нь таван жил, арван жил хадгалах гэж оролдвол түүнээс илүү хор хохиролтой тэсрэлт үүсэх аюултай байсан”

²⁹ (Горбачев М. , 1989)

³⁰ (Kramer, Fall 2003 x186)

³¹ (Шахнаразев, 1993 x368)

хэмээн мэдэгджээ³². Тиймээс 1988 оны сүүлч гэхэд Горбачев түүний зөвлөхүүд Зүүн Европт ЗХУ-ын бодлогыг хоёр гол зорилтын дэвшүүлсэн байна. Эхнийх нь “нууц меморандум”-д томёолсноор Ирээдүйд “онцгой” хямрал үүссэн тохиолдолд цэргийн интервенц хийхээс зайлсхийнэ” хоёрт, тайван гэхдээ гүнзгий шилжилтийг Зүүн Европийн орнуудад хийхийг хичээнэ, гарч болзошгүй янз бүрийн зөрчилдөөнд ЗХУ эерэг тайван шилжилт хийхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ” гэжээ³³. Хэрвээ нэг буюу хэд хэдэн оронд хямрал гүнзгийрч аюултай байдалд хүрвэл ЗХУ асар их хэмжээний материаллаг, улс төрийн, хүний хохирол амсахад хүрнэ гэж болгоомжлуулжээ. Үнэхээр ч “доргилтын үр нөлөө” гэж нэрлэдэг 1989 оны 6-р сард Хятадад болсон оюутнуудын хөдөлгөөнийг хүч хэрэглэн дарсан үйл явдал нь Горбачев болон түүний зөвлөхүүдийн багт онцгой нөлөө үзүүлжээ³⁴. Тиймээс энэ үйл явдлын дараа ЗХУ нь өөрчлөлт шинэчлэлтийг тайван замаар хийгдэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх ёстой бодлого улам үр хүчтэй болжээ.

Зүүн Германы лидерүүд Горбачевийн шинэчлэлийг шууд эсэргүүцэж байлаа. Зүүн Германы хувьд ардчилсан хөдөлгөөнүүд үүсэн бий болоход сүм хийдүүд чухал үүрэг гүйцэтгэжээ. Хамгийн анхны эсэргүүцэл сүмийн дотор 1982 оноос гарч эхэлсэн байна. Улмаар 1986 оноос “Энх тайвны санаачлага хүний эрхийн форм” бий болж 1987 оны 2-р сараас Хонекер Горбачев маягийн өөрчлөн байгуулалтыг эхлүүлсэн ба улмаар зургаан сард АНУ-ын Ерөнхийлөгч Р.Рейген Зүүн Германд айчилсан юм³⁵.

³² (Зуркин, 1990)

³³ (Шахнаразев, 1993 х368)

³⁴ (Kramer, Fall 2003 x189)

³⁵ (Kenney, 2002 x20)

М.Горбачев “өөрчлөн байгуулалт”-ын бодлогоо зарласны дараа социалист блокийн улс орнуудын лидерүүд ихэнхи нь эсэргүүцсэн бол харин иргэд нь дэмжиж байлаа.

Тухайлбал Румыны удирдагч Н.Чаушеску, БНАГУ-ын удирдагч Э.Хонеккер нар шууд эсэргүүцэж байлаа. Мөн Хойд Солонгосын Ким Ир Сен зэргийг нэмэх хэрэгтэй. Ялангуяа социализмын төгсгөл буюу 1986 оноос хойш социалист блокийн удирдагч нар дотроо хуваагдсан юм. Монгол орон нь эдгээр орнуудаас Польш, Зүүн Герман, Унгар, Чехословак гэсэн дөрвөн оронтой эдийн засгийн харилцаатай байлаа. Мөн өөрчлөн байгуулалтаас хойш эдгээр улс орны лидерүүд манай улсад айлчилж манай улсын дээд удирдлага эдгээр орнуудад айлчлах ажил ихэд идэвхжсэн юм. Тухайлбал “Өөрчлөн байгуулалт”-ыг эхнээсээ эсэргүүцэж байсан Румыны Ерөнхийлөгч Н.Чаушеску 1988 оны 4 сард, Чехословакийн коммунист намын ЕНБД Милос Жакес 5 сард Монголд айлчлал хийсэн бол Ж.Батмөнх 10 сард Польш ба Германд албан ёсны айлчлал хийжээ. Мөн Ж.Батмөнх зөвхөн 1987-1989 оны 12 сар хүртэл Болгар, Унгар, Польш зэрэг орнуудад яг энэ хугацаанд айлчлал хийв. Румыны Ерөнхийлөгч Николае Чаушеску 1988 оны 4 сард Монголд айлчилж Ж.Батмөнхтэй уулзаж төрийн дээд одонгоор шагнасан байна. Удалгүй Румыны ард түмний эсрэг хүнд гэмт хэрэг үйлдэж хүний эрхийг зөрчсөн гэдэг шалтгаанаар Ардын Депутатуудын хурлын 1988 оны 1 сарын 25-нд 12-р тогтоолоор Румыны өгсөн Сүхбаатарын одонг 1989 оны 12 сарын 30-ны өдөр цуцалж “дарангуйлагч” гэж нэрлэв³⁶. МоАХ-ын анхны шаардлагын нэг нь “1956 онд БНУУ, 1968 онд БНСЧСУ-ын дотоод хэрэгт Варшавын гэрээний орнууд зэвсэгт хүчээр хөндлөнгөөс

³⁶ (Unauthorised organization appears 1989 x6)

оролцсон явдлыг сайшаан дэмжсэн зэрэг үйл ажиллагаандаа МАХН-аас улс төрийн зохих дүгнэлт хийх” гэсэн байлаа. Тийм ч учраас 1989 оны 12 сарын 27-ны өдөр 1968 онд Варшавын гэрээний орнуудын цэрэг Чехословакид орсон явдлыг дэмжсэн өмнөх шийдвэрээ хүчингүй болгожээ³⁷. Ж.Батмөнх 1989 оны намар Зүүн Германд айлчлал хийсэн бөгөөд тэрээр энэ тухайгаа өөрийн дурдатгалдаа бичиж үлдээжээ. Тэрээр бичихдээ “10 сарын 7-нд хуучин БНАГУ-ын 40 жилийн ойг социализмын нэг томоохон баяр болгож нэлээд сүр дуулиантай тэмдэглэж билээ. Нам, төрийн тэргүүн нараар толгойлуулсан социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хамгийн дээд зиндааны төлөөлөгчид энэ баяр ёслолд оролцож социализмын сүр хүчийг бас дахин харуулахаар Берлин хотноо хуран цугларч билээ. М.Горбачев, В.Ярузельский, М.Якеш, Т.Живков, Н.Чаушеску, Нгуен Ван Линь нар орсны дээр Монголын нам, засгийн төлөөлөгчдийг тэргүүлэн тэрхүү баяр ёслолд оролцох үүрэг миний хувьд оногдсон билээ. Баяр ёслолын ажиллагаа өндөр зохион байгуулалттай, ёслол хүндэтгэлтэй болсон боловч яагаад ч юм цаанаа ямар нэгэн түгшүүртэй ч юм шиг байдал ажиглагдаж байлаа. Чухам энэ үед Унгарын Ажилчны Социалист намын их хурал хуралдаж намыг үндсээр нь шинэчилж Унгарын Социалист Нам гэдэг шинэ нам байгуулах шийдвэр гаргасан нь дэлхийн олон нийтийн анхаарлыг татсан үйл явдал болсон юм” гэжээ. У.Баркманн энэ үйл явдлыг нэлээд тодруулсан байдаг бөгөөд “Ёслолын үеэр олон мянган жагсагчид гудамжаар өгсөн ордныг чиглэн ирэхэд мөхөж буй социалист ертөнцийн зарим удирдагчид М.С.Горбачевийг даган ёслолын танхимыг яаралтай орхин гарсан байна. Ж.Батмөнх цөөн

³⁷ (Politburo annuls statement on "Prague spring" 1990 x5)

хэдэн удирдагчдын хамт ширээнээс босолгүй үлдэв. Германы Нэгдсэн Социалист намын ерөнхий нарийн бичгийн дарга Э.Хонекер түүнийг хажуудаа суухыг урьсан байна. Гэвч тэдний хооронд олигтой яриа өрнөсөнгүй. Тэдний сэтгэл дор бүртээ л хямран байхад гадаа гудамжинд Аюулаас хамгаалахын онцгой ангийнхан цагдаа нартай хамтран ордны өмнөх талбай дээр жагсагчдыг зодож нүдэж байсан аж. Ж.Батмөнх хожим нь ордны өмнө болсон энэхүү үйл явдлын тухай маш тодорхой мэдээлэлтэй болжээ. Тэрвээр Зүүн Германы нийслэл хотыг тун гүнзгий бодолд дарагдан, дуу муутайхан орхин одов. Нутаг буцах аян замын туршид түүний ой ухаанд нутгийнхаа иргэдийн эсрэг хэзээ ч хүч хэрэглэж болохгүй гэсэн бодол баттай суусан буй за”³⁸ гэжээ. Үнэхээр ч “Хүйтэн дайн” хэмээх алдарт баримтат кинонд Ж.Батмөнхийн дүрс орсон энэ хэсэг нь үлдсэн байдаг, мөн Зүүн Германы ой тэмдэглэх үеэр жагсагчдын үйл ажиллагаа хэрхэн идэвхжиж байгаа тодорхой харуулдаг³⁹. Ж.Батмөнхийн дурдатгалаас үзэхэд энэ үйл явдал түүнд багагүй нөлөө үзүүлсэн гэдэг нь харагддаг бүхэн нь түүнд багагүй зүйлийг ойлгуулсан нь эргэлзээгүй⁴⁰. Горбачёв ба Чаушеску, Хонеккер нарын бүгдтэй нь уулзаж өөрчлөн байгуулалтын талаар саналаа солилцож явсан Ж.Батмөнхийн хувьд ирж яваа цагийн талаар тодорхой төсөөлөлтэй болоод байв.

Соёлын харилцааны тухайд Удо Баркманы хэлсэн “Зүүн Европт болж буй үйл явдлын тухай мэдээлэл Улаанбаатарт тойруу замаар л хүрнэ гэсэнтэй зарим талаараа санал нийлэхгүй байна⁴¹. Юуны түрүүнд Зүүн Европт болж байгаа мэдээллийг иргэд Зөвлөлтийн ТВ-ээс шууд авч байжээ, өөрийн хэвлэл бол зөвхөн нэмэлт тайлбартайгаар

³⁸ (Баркман, 2008 х126)

³⁹ (CNN 2004)

⁴⁰ (Батмөнх, 2001х41)

⁴¹ (Баркман, 2006х125)

мэдээлж байв. Зүүн Европийн орнуудын Монголын өөрчлөн байгуулалтанд үзүүлсэн шууд бус дээр дурдсан хүчин зүйлээс гадна шууд нөлөө үзүүлэх хүчин зүйл байлаа. Энэ бол социалист улс орнуудын хоорондын гэрээний дагуу тэдгээр орнуудад суралцагчид юм. Намтарын судалгаагаар тухайн үед тус улс орнуудад суралцсан хүмүүсийн тоо нэлээд байсан юм. Үүнийг бусад суралцагчтай, мөн нийт оролцогчтой харьцуулан шинжилгээг хийх шаардлагатай байгаа юм. Зөвхөн удирдагч нарын хувьд аваад үзвэл МоАХ-ны анхны зохицуулах зөвлөлийн дотор Унгарт сурсан Г.Бошигт, Германд сурч байсан Дарь.Сүхбаатар, АСХ-ны удирдагчдын дотор Польшид сурсан Баабар, А.Ганбаатар хоёр, МОХ-ны лидер Л.Болд нь Германд сурсан байжээ. Үүнээс харахад судлаачдын бичдэг зүйлс үндэслэлтэй гэдгийг харуулж байна. Суралцагчдын тоо, юуны түрүүнд монголын анхны ардчиллыг дэмжигчид эдгээр орнуудад суралцагчид байв. Энэ тухай М.Россаби, Фриц зэрэг онолчид онцгойлон дурдсан. Үүнийг хувьсгалын “диффузи” гэж нэрлэдэг. МоАХ, АСХ, ҮДХ-г байгуулагчид болон идэвхтэнүүд дотор Зүүн Европийн орнуудад сурч байсан бүлгүүд олноороо нэгдсэн. Тэд тооны хувьд ЗХУ-д “өөрчлөн байгуулалтын үед” сурч вирусдсэн бүлгээс тооны хувьд цөөн ч хүчтэй бүлэг байв. Зүүн Европийн орнуудаас ялгаатай нь Монголд улс төрийн сөрөг хүчин, тэрс үзэлтнүүд, гадаадад дүрвэн гарсан “бүлгүүд” байгаагүй юм⁴². Тэгвэл ардчиллыг дэмжигчид хаанаас үүсэв? Монголын “өөрчлөн байгуулалт”-ын үйл явцад Зүүн Европийн социалист улс орнууд ихээхэн нөлөөг үзүүлээ. Зөвхөн сурч төгсөж ирснээс гадна тухайн үед сурч байсан оюутнууд бас тодорхой нөлөөг үзүүлсэн юм. Тухайлбал гадаадад суралцагч Монгол оюутнуудыг

⁴² (Atwood, 2004 x143-44)

сонгуульд оролцуулах зорилгоор “Гадаадад суралцагч Монгол оюутны анхдугаар бага хурал”-ыг 1990 оны 7-р сарын 6-ны өдөр хийж байсныг дурдах хэрэгтэй⁴³.

Комеконы (Comecon or CMEA) тусламж дэмжлэг зогсов

Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөл⁴⁴ нь 1949 онд байгуулсан бөгөөд Монгол нь 1950 онд ажиглагчаар уригдсан бөгөөд 1962 оноос бүрэн гишүүн болсон байна. Улмаар Монгол нь тус байгууллагын гишүүн бусад орнуудаас хөнгөлөлтэй нөхцөлөөр жилийн хоёр хувийн хүүтэй зээл авдаг байсан бөгөөд зээлийг төлөх боломж байхгүйг харгалзан өрийг хойшлуулдаг бөгөөд ингээд зээл улам бүр нэмэгддэг байжээ⁴⁵. Нэгд, шууд зөвлөлтийн эдийн засгийн ашиг сонирхолд нийцсэн бодлогыг явуулдаг байв, хоёрт, зөвлөлтийн гадаад геополитикийн бодлогын тусгал нь энэхүү байгууллагаар дамжин илэрч байв. Тухайлбал уг байгууллагын гишүүн гол орнууд нь Зүүн Европт байхад тэдний хувьд эдийн засгийн ямар ч ашиг сонирхолгүй Куба, Монгол Вьетнамд орнуудад 80-аад оны сүүл гэхэд асар их хөрөнгө оруулалт, зээл тусламжийг өгсөн байжээ. Тухайлбал 1987 оны байдлаар нийт Комеконы тусламжийн дөрөвний гурав нь энэ гурван оронд ноогдож байв. Энэ гурван орон нь геостратегийн зорилготой учраас асар их хөрөнгө оруулалт дэмжлэгийг хүртэж байв⁴⁶. Харин зүүн Европийн 6 орны ихэнхийн нь хувьд үзэл суртал, коммунист удирдлагуудын бодлогын улмаас энэхүү байгууллагын гишүүн болж явж байсан бөгөөд улмаар тэдгээр орнуудад дэглэм

⁴³ (Дашзэвэг, 1998x81)

⁴⁴ (“Council for Mutual Economic Assistance” гэдгийг монгол хэлнээ Эдийн Засгийн Харилцан Туслах зөвлөл (ЭЗХТЗ) хэмээн нэрлэдэг)

⁴⁵ (Батмөнх, 2001x35)

⁴⁶ (Raymond, 1991x871)

солигдмогц шинэ удирдлага энэ байгууллагаас яаралтай гарсан юм. Гуравдугаарт, Монголын хувьд энэ байгууллага асар их үр хөрөнгө оруулалт, зээл тусламжийг өгч “эсгий гэр хот”-ийг орчин үеийн соёлжиж иргэншсэн улс орон болоход хүчтэй эдийн засгийн нөлөөг үзүүлсэн юм. Тийм ч учраас монголчуудын хувьд энэхүү байгууллагын гишүүн болсон нь алдсанаасаа илүүтэй хожсон билээ.

БНХАУ-ын Тянанмений шийдэл

1990 оны Монголын ардчилалын үйл явцыг судлахад монголын гадаад геополитикийн нөхцөл байдал, хэрхэн өөрчлөгдөж ирсэн нь туйлын чухал байдаг. Үүнд ЗХУ ба БНХАУ-ын харилцаа, БНМАУ болон БНХАУ-ын харилцаа онцгой хамааралтай юм. ЗХУ, БНХАУ-ын харилцаа 1960 оны дундуур хурцдаж улмаар монгол нь ЗХУ-ын “дагуул” улсын хувьд БНХАУ-тай харилцаагаа муутгаж байжээ. Энэ талаар хоёр янзын байр суурь барууны эрдэмтэдийн дунд байна. Улмаар Сонигийн тайлбарласнаар 1980-аад оны эхээр Л.Брежневийн удирдлагын сүүлийн жилүүдэд Дэн Ся Пэний Хятадтай дайсагнахаа зогсоож улмаар хоёр талын харилцаагаа шинээр эргэн харж эхэлжээ⁴⁷. Л.Брежнев “Зөвлөл засгийн газар нь Хятад улсыг социалист улс, Тайваныг Хятадын хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байна” хэмээн мэдэгдэл хийж байжээ. Бээжин хариуд нь найрсаг мэдэгдэл мөн хийжээ⁴⁸. Дараагийн шатанд М.С.Горбачёв улс төрийн шинэ сэтгэлгээ хэмээн нэрлэсэн гадаад бодлогын шинэ номлол ЗХУ ба БНХАУ хоёрын хоорондын харилцаанд шууд нөлөөлжээ. Тэрээр 1987 оны “Владивостокийн санаачлага” хэмээх алдартай мэдэгдлээ хийж өнгөрсөн хугацаанд явуулж байсан Ази, Номхон Далайн бүс нутгийн

⁴⁷ (Sharad K, 2006 x183)

⁴⁸ (Sharad K, 2006 x187)

улс төрийн бодлогоо бүхэлд эргэж харахаар зарлав⁴⁹. Горбачев **нэгд**, хоёр орны харилцааг сайжруулж сайн хөршийн ёсоор энх тайванчаар зэрэгцэн оршиход бүхий арга хэмжээг бүх шатанд авахад бэлэн байгааг зарласан, **хоёрт**, ЗХУ нь хятадын Амар мөрнийг шинэчлэх зорилт болон хоёр орны хоорондын албан ёсны хилийг ойлгож хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлж, **гуравт**, Монгол болон Зөвлөлтийн удирдлагууд зөвлөлтийн цэргийн зарим хэсгийг монголоос гаргах асуудлыг авч үзэж байгааг илэрхийлж, **дөрөвт нь**, Афганистанаас цэргээ гаргах асуудлыг авч үзнэ гэжээ⁵⁰. Үнэхээр удалгүй зөвлөлтийн цэрэг үе шаттайгаар монголоос гарах асуудал хөндөгдсөөр улмаар 1989 онд бүрэн тохиролцсон. Эдийн засгийн учир шалтгаантай ЗХУ-ын шинэ гадаад бодлого нь Монголчуудад гадаад харилцааны шинэ боломжуудыг нээж өгч байв. Тиймээс монголчууд өмнөд хөрштэйгээ харилцаагаа сайжруулах боломжтой боллоо.

Монгол, Хятад орон нь өөр хоорондоо зөрчилдөх түүхийн учир шалтгаан байсан юм. Э.Грины судалснаар дараах хэдэн гол хүчин зүйлүүд нөлөөлдөг үүнд **нэгд**, энэ хоёр орны түүхийн харилцаа, ялангуяа Хятадын монголын талаар “алдагдсан нутаг” хэмээн үзэж оролдлого ба Монголчуудын Манжийн удирдлаганд байсан дурсамж, **хоёрт**, хүн амын асуудал, энэ нь хятад дахь монгол этник цөөнхийн асуудал ба Хятадын хэт их хүн ам нь халхын газар нутаг руу эзлэлтээс айх Монголчуудын айдас, **гуравт**, Хятадын үндэсний цөөнх тэр дотроо өвөрмонголчуудад явуулж байгаа бодлого, **дөрөвт**, хятадын заналхийллээс Монголын аюулгүй байдлын асуудлыг зөвлөлтийн цэргийг оролцуулан шийдэх зэрэг болно⁵¹.

⁴⁹ (Sharad K 2006 x192)

⁵⁰ (Sharad K 2006 x194)

⁵¹ (Green, 1986 x1337).

Дээрх хоёр их гүрний харилцаа бүлээрч ирсэн нь БНХАУ ба БНМАУ хоёрын хоорондын харилцаа сайжрахад шууд нөлөөг үзүүлж эхэлжээ. Монголын талын хамгийн анхны мэдэгдлийг Ю.Цэдэнбал Үнэн сонинд 1981 оны 6 сарын 19-ны өдөр хэвлэжээ. 1983 онд Хятадын үндэсний баяраар Монголын элчин сайд Хятадын элчин сайдын яамны хүлээн авалтанд очсон нь анхных бөгөөд 1984 онд БНМАУ-ын гадаад харилцааны орлогч сайд Д.Ёндон Хятадад айлчилсан нь анхны өндөр төвшний албан тушаалтны айлчлал болжээ⁵². Удалгүй “хятад ажилчид”-ын асуудал гарсан хэдий ч улмаар хоёр орон харилцаагаа сайжруулахаар хоёр талаасаа тодорхой алхмууд хийсээр байв. 1986 онд хоёр орны хооронд худалдааны гэрээ байгуулагдаж, мөн шууд нислэг хийгдэж, 1985 онд Нью-Йоркод болсон НҮБ-ийн 40 жилийн ойн баярын үеэр БНМАУ-ын гадаад харилцааны яамны сайд М.Дүгэрсүрэн, БНХАУ-ын гадаад харилцааны яамны сайд Ву нар анхны уулзалтыг хийжээ⁵³. Үүний дараа 1986 оны 5 сард хуралдсан МАХН-ын XIX их хуралд МАХН-ын ЕНБД Ж.Батмөнхийн тавьсан илтгэлд “БНМАУ Бүгд Найрамдах Хятад Ард улстай харилцаагаа хэвийн болгох зарчимч чиг шугамаа тууштай баримталсаар байна. Эрх тэгш байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчмыг хатуу баримтлах үндсэн дээр хоёр орны хоорондын сайн хөршийн харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Монгол, Хятадын ард түмний эрх ашигт болон энх тайван, социализмын үйлсийн эрх ашигт нийцнэ гэж үзэж байна” гэжээ⁵⁴. Дараа нь Монголын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн 1989 оны 3 сард БНХАУ-д айлчилж, улмаар 8 сард БНХАУ-ын ГЯЯ-ны сайд Цянь

⁵² (Sharad K 2006 x187)

⁵³ (Sharad K 2006 x189)

⁵⁴ (Монгол ардын хувьсгалт намын XIX их хурал, 1986x25)

Цичен Монголд айлчилжээ⁵⁵. У.Баркманн энэ тухай “ЗСБНХУ-ын Засгийн газар БНХАУ-тай харилцаагаа сайжруулахыг хичээж буйгаа харуулах үүднээс бүр 1987 оны 4 сард “БНМАУ-д түр хугацаагаар байрлуулсан Зөвлөлтийн цэрэг”-ийн (тэднийг албан ёсоор ингэж нэрлэдэг байв) бүрэлдхүүнд байсан буудлагын бүрэн моторжуулсан нэг дивиз болон хэд хэдэн тусгай ангийг эргүүлэн татсан байв” гэжээ⁵⁶. Ингээд хурцадмал байсан харилцаа сэргэж эхлэв.

1990 оны Монголын ардчиллыг судлахад БНХАУ-д өрнөсөн оюутнуудын эсэргүүцэл, Тянь Мян Аний талбайд оюутнуудыг нухчин дарсан үйл явдал зайлшгүй дурдагддаг. Үүний шалтгаан нь *нэгдүгээрт*, хоёулаа хөрш зэргэлдээ оршдог, *хоёрдугаарт*, хоёулаа ижилхэн Азийн социалист улс төрийн тогтолцоотой орон, *гуравдугаарт*, нэгэн цаг хугацаанд социалист улс төрийн тогтолцоог өөрчлөх шинэчлэлийн хөдөлгөөн оюутан залуучууд, сэхээтнүүдийн дунд ижилхэн үүссэн гэдгээрээ адил. Харин эдийн засгийн хүчин чадал, зах зээлд шилжсэн төвшин, мөн үүсээд байсан сөрөг хүчний эсэргүүцлийг хэрхэн шийдвэрлэсэн ба цаашид сонгосон зам чиглэл нь хоёр өөр юм. Дарааллын хувьд хятадын хэрэг явдал⁵⁷ нь монголын улс төрийн товчоо огцрохоос 9 сар, анхны жагсаалаас 6 сарын өмнө болсон. Анх хятадын шинэчлэгч нэрт улс төрч Ху Ябангийг 4 сарын 15-нд зүрхний аттакаар нас барсанд гашуудан 4 сарын 17-ноос төв талбай дээр Бээжингийн их сургуулийн улс төрийн ба хуулийн ангийн хэдэн зуун оюутнуудын эхлүүлсэн жагсаал 4 сарын 20-нд цагдаа нартай мөргөлдөж улмаар 4 сарын 22-ны өдөр 50,000 орчим хүн оролцож, 4 сарын 27-ны өдөр 100,000 оюутны жагсаал болж

⁵⁵ (Пүрэвдорж, 2001 х178)

⁵⁶ (Баркманн 2008 х25)

⁵⁷ (Zhao, The power of Tiananment, 2001)

өргөжжээ. Улмаар 5 сарын 13-нд 300 оюутан өлсгөлөн зарлаж эхэлсэн ба улмаар 5 сарын 15-нд Горбачев Бээжинд ирсэн байна. Улмаар 6 сарын 3 гэхэд цэргийн ажиллагаа эхэлж хэдэн зуун хүн алагдсан бөгөөд 6 сарын 4-ны өдөр 4,000 оюутан цэргүүдээр бүслүүлэн төв талбайг орхин явж уг асуудал дуусчээ⁵⁸. Россابي нарын барууны судлаачдын үзэж байгаагаар хятадын шийдэл нь монголын удирдагч нарын шийдвэрт нөлөө үзүүлсэн болов уу⁵⁹ гэжээ. Тэгэхлээр хөрш орны “шийдэл” нь ойр зэргэлдээ байгаа улс орнуудад үзүүлэх нөлөөг “диппузи” гэж заримдаа нэрлэдэг. Ийм үзэгдэл үүссэн байж болох талтай юм. Учир нь Румыны үйл явдал Европийн социалист орнуудад зохих нөлөө үзүүлсэн бол БНХАУ-ын шийдэл нь Монголд сайн шийдэл гаргахад шууд бусаар нөлөөлсөн нь гарцаагүй. Энэ хооронд БНХАУ-ийн удирдагч нар төв талбайдаа жагсаал хийж эсэргүүцэл зарласан оюутнуудыг цэргийн хүч хэрэглэн харгислан дарсныг дэлхий нийтээрээ тэр дотроо М.Горбачёв буруушааж байлаа⁶⁰. Энэ үйл явдал нь Ж.Батмөнх БНХАУ-тай харилцаагаа сэргээхэд нь саад болсонгүй⁶¹. Үүнтэй холбоотой “Тянь Мян Анийг эмгэнэн дурсаж байна” нэртэй мэдэгдэл “Ардчилал” сонинд хэвлүүлж оюутнууд БНХАУ-ын элчин сайдын яамны гадаа суулт хийжээ⁶². Манай талаас албан ёсоор мэдээлэл гаргаж буруутгаагүй ч гэсэн БНХАУ-ын удирдагчдын үйлдлийг дэлхий даяар эрс шүүмжилсэн бөгөөд энэ бодлогын нөлөө нь Монголын ардчилалд шууд бусаар нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. Үүнийг хөрш орнуудын шийдлийн эсрэг нөлөө гэж хэлж болох юм.

⁵⁸ (Zhao, The power of Tiananment, 2001 x XXV-XXVI)

⁵⁹ (Rossabi, 2005)

⁶⁰ (Zhao 2001)

⁶¹ (Rossabi, 2005 230x)

⁶² (Цэнгэлт, 1990)

Гурав дахь сонирхолтой холбоо бол ажиглагчдын үзэж байгаагаар Монголын ардчилал нь хил залгаа БНХАУ-ын өвөр монголын нутагт байгаа монголчуудад “халдварлаж” дотоод үндэстэн хоорондын тогтворгүй байдал үүсэхээс БНХАУ-ын удирдагч нар болгоомжилж байсан юм⁶³. Үүнийг БНХАУ-ын мэдээллийн агентлагууд 1989-1990 оны туршид монголын талаар “ардчиллын талаархи” мэдээллийг орхигдуулан мэдээлж байснаас харж болно. Чухам яагаад ингэж БНХАУ-д Монголд болж байгаа энэ үйл явдлын мэдээллийг өргөнөөр мэдээлэхээс татгалзаж байлаа. Тухайлбал хятадын нэр хүндтэй “Синхиа” агентлагын 1990 оны Монголын тухай мэдээнүүдийг шүүгээд үзэхэд жагсаал, цуглаан, ардчилсан холбооны талаар мэдээ бараг байхгүй бөгөөд харин гэмт хэрэг өсч байгаа, тухай эдийн засгийн нөхцөл байдалд хүнд байгаа тухай л мэдээн дээр л төвлөрч байсныг ингэж тайлбарлахаас өөр аргагүй. Ялангуяа Монголд өрнөж байгаа ардчилсан хүчнийг шүүмжилсэн мэдээг МоАХ-ын албан ёсны хэвлэл “Ардчилал”-д орчуулан тавьж байлаа⁶⁴. Үнэхээр ч Монголд өрнөсөн ардчилсан хувьсгал Хятадын нэг хэсэг болох өвөр монголчуудад нөлөө үзүүлж болзошгүй байв. Тухайлбал өвөр Монголоос зугтаж орж ирээд Монголд амьдарч 1989 онд Монголын иргэн болсон Аюурзанын Өлзийбаярын жишээн дээрээс харахад Монголд зугтан орж ирсэн өвөрмонголчууд ардчилсан хөдөлгөөн байгуулагдсан анхны өдрөөс эхлэн дэмжиж жагсаал цуглаанд нь идэвхтэй оролцож ирсэн байна. МоАХ-ны анхны их хурлын үеэр мөн өвөрмонголоос Монголд оргон гарч ирсэн Итгэлт, Дөлгөөн, Түмэнбаяр нар, Өлзийбаярын охидтой хамт “МоАХ-ны их хуралд Өвөрмонголын залуучуудаас халуун баяр хүргэе” гэсэн лоозон алд

⁶³ (Milivojevic' 1991x25)

⁶⁴ (Бээжингийн радио Синхиа агентлагийн мэдээнээс, 1990)

цагаан хадгийг хамт гардуулж байжээ⁶⁵. Мөн тэр үед Монголд МУИС-д түүхийн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалахаар сурч байсан Д.Мөрөн МоАХ-г ихэд дэмждэг байжээ. С.Амарсанаагийн номонд ч гэсэн ардчиллын эхний өдрүүдэд Б.Энхтөвшин П.Нэргүйн гэрт зөвшөөрөлгүйгээр “өвөрлөгч хүн” авчирсан гэсэн шалтгаанаар буруутгагдаж байсныг дурдсан нь Мөрөнг хэлсэн болов уу⁶⁶. Улмаар Мөрөн эрдмийн зэрэг хамгаалах ажлаа орхин өвөрмонголчуудын тусгаар тогтнолын төлөөх “Дэ ван” хэмээх нийгэмлэгийг байгуулан тэмцэж эхэлсэн бөгөөд улмаар 2009 онд Шведэд цагаачилж гараад нас барсан байдаг. А.Өлзийбаяртай хамтдаа өвөрмонголоос зугтаж ирсэн Алтанбат нь ардчилсан хувьсгалд маш идэвхтэй оролцсон бөгөөд “Ардчилал” сонинд өвөрмонголын монголчуудын талаар олон зүйлийг нийтэлж байсан бөгөөд улмаар 1997 онд АНУ-д Өвөрмонголчуудын эрх ашгийг хамгаалахын төлөө “Өвөрмонголын ардын нам”-ыг байгуулжээ⁶⁷.

Гадаад харилцааны бодлого өөрчлөгдөв

Өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр Монголын гадаад харилцааны бодлого үндсээрээ өөрчлөгдөж Зөвлөлт Хятадын хооронд орших, зөвлөлтийг олон жилийн турш үнэнчээр дагасан “дагуул” орны гадаад бодлогод ч өөрчлөлт оров⁶⁸. Ж.Батмөнхийн хэлснээр “1986 оны эхээр тэр үеийн ЗСБНХУ-ын Гадаад явдлын яамны сайд байсан Э.Шевардназе манай оронд айлчлахдаа Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа тогтооход ЗХУ нааштай хандаж байгаа тухайгаа бидэнд илэрхийлсэн билээ. Урьд өмнө Монгол Америк хоёр

⁶⁵ (Өлзийбаяр, 2012x424)

⁶⁶ (Амарсанаа, 2011)

⁶⁷ (Өлзийбаяр, 2012x491)

⁶⁸ (Campi, Alicia and Baasan, R, 2009x394)

талаас нэг биш удаа хүчин чармайлт гаргасан боловч хажуугийн шалтгаанаар хэрэгжиж чадаагүй хойшлогдож ирсэн чухал асуудлыг” 1987 оны 1 сард БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноор шийдвэрлэжээ⁶⁹. 1990 он гэхэд хоёр орны хоорондын худалдааны эргэлт 900,000 ам долларт хүрч монголын экспорт нь ноос, ноолуур зэргээс бүрдэж байсан юм⁷⁰. Ингэж АНУ-тай дипломат харилцаа тогтоосон нь Монгол орныг ардчилагдах үйл явцад чухал нөлөөг үзүүлжээ. Энэ нь эдийн засгийн тал дээр 1991 онд ЭЗХТЗ задарч ЗХУ-аас үзүүлж байсан албан ёсны зээл тусламж зогсоход АНУ-ын удирдагч нар Монголыг олон улсын банк санхүүгийн байгууллагад элсэн орох, мөн хандивлагч нарыг зохион байгуулах координац хийх ажлыг санаачлахад чухал үүрэг гүйцэтгэв. Монгол орныг ардчилагдах үйл явцад нөлөө үзүүлсэн гадны бас нэг орон нь Япон улс билээ. Чухамдаа Халх голын дайны үеэс хойшхи Монгол Японы харилцаа аажим аажмаар сэргэсээр эдийн засаг, соёлын салбараас эхэлсэн харилцаа 1988 оноос Японд манай гадаад яамны сайд албан ёсны айлчлал хийснээр богино хугацаанд амжилттай хөгжиж чадсан. Ялангуяа ЗХУ өөрийн зээл тусламжийг үргэлжүүлэн үзүүлэхээс албан ёсоор татгалзаж эхлээд⁷¹ байсан үед Япон орон Монголд ихээхэн хэмжээний хандив зээл, тусламжийг шилжилтийн үед үзүүлж хүнд хэцүү үеийн давж гарахад тусалсан. Мөн 1989 оноос БНСУ-тай дипломат харилцаа тогтоох төлөөлөгчдийн уулзалтууд эхэлж, 1989 онд Азийн хөгжлийн банкинд гишүүнээр элсэх хүсэлтээ

⁶⁹ ”(Батмөнх, 2001 х34)

⁷⁰ (Campi, Alicia and Baasan, R, 2009х394)

⁷¹ (Ситников, 1990)

гаргаад байв. Мөн онд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгтэй дипломат харилцаа тогтоосон байна⁷².

Дүгнэн үзвэл энэ ийм хүчин зүйлүүд нь Монголд ардчилал үүсэхэд, мөн хуучин дэглэмийн удирдагч нар өөрсдийн сайн дураараа огцроход мөн анхны чөлөөт ардчилсан сонгууль явагдахад тэр дотроо ардчилсан тогтолцоо бүрэлдэхэд шууд болон шууд байдлаар нөлөөлжээ.

(Энэхүү өгүүлэл НШУС-ийн багш Ч.Тамирын эрдмийн зэрэг хамгаалах ажлын хүрээнд хийгдэж байгаа судалгааны ажлын хэсэг, цуврал өгүүллийн хоёр дах юм. Уг өгүүллийн эхний хэсэг 2012 оны “Социологи” сэтгүүл дээр Ч.Тамир “Монголын өөрчлөн байгуулалт: дотоод хүчин зүйл” нэртэйгээр хэвлэгдэн гарсан болно.)

Ашигласан ном зүй

I. Монгол хэлээр:

1. Амарсанаа, С. (2011). Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. Улаанбаатар: МН-Технологи.
2. Болд-Эрдэнэ, Д. (2000). Монголын улс төрийн нам, намын систем. Улаанбаатар.
3. Баркман, У. Б. (2008). Монгол улсын шилжилтийн үеийн улс төрийн намуудын үүрэг. Улаанбаатар.
4. Батмөнх, Ж. (2001). Хүч хэрэглэж хэрхэвч болохгүй. Улаанбаатар: Интерпресс.
5. Бээжингийн радио Синхуа агентлагийн мэдээнээс. (1990 оны Тавдугаар сарын 10-20). Ардчилал, р. 2.
6. Горбачев, М. С. (1988). Өөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ: Манай оронд болон дэлхий дахинд. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн газар.
7. Дашзэвэг. (1998). МҮАН-ын түүхэн тэмдэглэл. Улаанбаатар: Интепресс.

⁷² (Намжим, 2000х714-15)

8. Монгол ардын хувьсгалт намын XIX их хурал. (1986). Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
9. Намжим, Т. (2000). Монголын аж ахуй эдийн засаг. Улаанбаатар 2-р боть: Интерпресс.
10. Өлзийбаяр, А. (2012). Монголдоо тэмүүлсэн сэтгэл. Улаанбаатар.
11. Пүрэвдорж, Д. (2001). Цагаан морин жил. Улаанбаатар: Монголын уран зохиолын академи.
12. Ситников, В. (1990 оны Хоёрдугаар сарын 26). Зөвлөлт, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн хэтийн төлөв. Үнэн, р. 4.
13. Цэнгэлт, Г. (1990 оны Зургаадугаар сарын 1-10). Тянь Ань Мэнийг эмгэнэн дурсаж байна. Ардчилал, р. 1.
14. Янжинлхам, Б. (2012). Би монгол хүний саруул ухаанд итгэдэг юм. Улаанбаатар: Адмон.

II. Орос хэлээр:

1. Ведомости Верховного Совета РСФСР, 1987
2. Горбачев, М. (1989 оны Июль 7). Речь. Известия, р. 2.
3. Закон о гласности. (1987 /12/). Гласности.
4. Закон СССР о кооперации в СССР. (1988 оны June). Известия.
5. Зуркин, В. (1990 оны Май 26). Европа менеечешкая координатах. Известия, р. 5.
6. Шахнаразев, Г. (1993). Цена свободы: Реформация Горбачева глазами его помощника. Москва: Русско-Зевс.
7. Яскина, Г. (2007). Трансформация монгольского общества в конце XX века (1984-2000 гг.). In Р. Рыбаков, История Монголии XX века (pp. 313-395). Москва: ИВ РАН.

III. Англи хэлээр:

1. Atwood, C. P. (2004). Encyclopedia of Mongolia and the Mongol Empire. New York: Facts on File. New York: Facts on File.
2. Campi, Alicia and Baasan, R. (2009). The Impact of China and Russia on United States-Mongolian Political relations in the twentieth century. Lewiston Queenston Lampeter: The Edwin Mellen Press.

3. Fish, S. (1998). Mongolia: Democracy Without Prerequisites. *Journal of Democracy* , 127-41.
4. Fish, S. (2000). The Inner Asian Anomaly: Mongolia's Democratization in Comparative Perspective. *Mogolian Political and Economic Development During the Past Ten Years and Future Prospect*, (pp. 87-110). Taipei.
5. Fritz, V. (2008, August). Mongolia: The Rise and Travails of Deviant Democracy. *Democratization* , 766-788 .
6. Kramer, M. (Fall 2003). The Collapse of East European Communism. *Journal of Cold War Studies* , 178-256.
7. Kenney, P. (2002). A carnival of revolution. *Central Europe 1989*. New Jersey: Princeton University Press.
8. Matthews, M. (1989). Party, State, and Citizen in the Soviet Union (A collection of documents). Armonk, New York, London, England: M.E. Sharpe, Inc.
9. Milivojevic', M. (1991). The Mongolian Revolution of 1990 Stability or Conflict in Inner Asia. London: Research Institute for the Study of Conflict and Terrorism.
10. Politburo annuls statement on "Prague spring". (1990 оны January 11). FBIS EAS, p. 5.
11. Raymond, E. (1991). Soviet Union. A country study. Washington.
12. Rossabi, M. (2005). Modern Mongolia. From Khans to commissars to capitalists. Berkeley: University of California Press.
13. Sharad K, S. (2006). Mongolia-China relations. New Delhi: Pentagon Press.
14. Turner, T. (Director). (1998). CNN Cold war, 24 [Motion Picture].
15. Unauthorised organization appears. (1989 оны December 19). FBIS EAS89,p. 6.
16. Watson, E. (1997). The collapse of communism in the Soviet union. Connecticut London: Greenwood Press, Westport.
17. Zhao, D. (2001). The power of Tiananmen. Chicago and London: The university of Chicago press.